



## "УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 07 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар: 21/12

Улаанбаатар  
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
  - 2.1. "Номин Реалтор" ХХК-тай байгуулсан Барилгын ажлын захиалагчийн эрх шилжүүлэх гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг батлах.
  - 2.2. "Номин Реалтор" ХХК-тай байгуулах Түрээсийн гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй бөгөөд их хэмжээний хэлцлийг батлах.
  - 2.3. "Улсын их дэлгүүр" ХК нь Хаан банкнаас бага хүүтэй зээл авахтай холбоотойгоор "Номин холдинг" ХХК батлан даалт гаргах тул Улсын их дэлгүүрийн барилгыг гуравдагч этгээдэд барьцаалуулах эрхийг "Номин Холдинг" ХХК-д олгох асуудал.
3. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдөр, 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдрүүдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөр тасалбар болгосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загварыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материал, шийдвэрийн тэсэлтэй хувьцаа эзэмшигчид Нийслэлийн Хан-Ул дүүргийн 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт байрлах "Номин юнайтед" цогцолборын 5-р давхарт ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга дээр

Даваагаас Баасан гарагуудад ажлын цагаар танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.


9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалыг брокер дилерийн компаниудаар дамжуулан тараахыг зөвшөөрсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу "Номин юнайтед" цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар ТҮЗ-ийн дарга Санжаагийн Сайнбатыг томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын үүргийг Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт заасны дагуу гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр тогтоосугай.
13. Тооллогын комисс томилсон тогтоолыг тусад нь гарган баталгаажуулж, холбогдох эрх бүхий байгууллагад мэдээллийг хүргүүлсугай.
14. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх И.Галбуян, гишүүдээр ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

ТҮЗ-ИЙН ДАРГА



С.САЙНБАТ

ТУЗ-ийн 2021 оны 07-р сарын 23-ны өдрийн  
21/12 тоот тогтоолын Хавсралт №1



**“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 09-р сарын 01-ний өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Компани“Номин реалтор” ХК-тай байгуулсан Барилгын ажлын захиалагчийн эрх шилжүүлэх гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй бөгөөд их хэмжээний хэлцлийг батлах.
2. Номин реалтор” ХК-тай байгуулсан Түрээсийн гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй бөгөөд их хэмжээний хэлцлийг батлах.
3. “Улсын их дэлгүүр” ХК нь Хaan банкнаас бага хүүтэй зээл авахтай холбоотойгоор “Номин холдинг” ХК батлан даалт гаргаж байгаа тул Улсын их дэлгүүрийн барилгыг гуравдагч этгээдэд барьцаалуулах эрхийг “Номин холдинг” ХК-д олгох асуудал.

Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 08-р сарын сарын 17-ны өдрөөр тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал урьдчилан авах сүүлчийн хугацааг 2021 оны 08-р сарын 24-ний өдрөөр тасалбар болго ба саналаа брокер дилиериин компаниуд болон Нийслэлийн ХУД-ийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт байрлах “Номин юнайтед” цогцолборын 5-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн даргад ирүүлнэ.

Хувьцаа эзэмшигчид саналын хуудас, хурлын материал, шийдвэрийн төсөлтэй дээрх хаягаар, Даваа-Баасан гарагуудад, ажлын цагаар иргэний цахим үнэмлэхтэйгээ ирж танилцах боломжтой.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид цахим хуралд оролцох холбоос /линк/, зааварчилгааг 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс хойш Даваа-Баасан гарагуудад ажлын цагаар дээрх хаягт өөрийн биеэр, иргэний үнэмлэхтэйгээ ирж авах буюу ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ulziibat.jb@gmail.com хаягруу өөрийн овог, нэр, регистрийн дугаар бүхий хүсэлтийг илгээж авах боломжтой.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

**Утас: 89885120**

**Цахим хаяг: ulziibat.jb@gmail.com**

**Цагийн хуваарь: Даваа-Баасан 09:00-18:00**

ТУЗ-ийн 2021 оны 07-р сарын 23-ны өдрийн  
21/12 тоот тогтоолын Хавсралт №2



“Улсын их дэлгүүр” ХК-ийн 2021.09.01-ний өдрийн  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудас

Хурал хуралдах газар /хаяг, байршил/: Хурал цахим хэлбэрээр болно.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: .....

Хувьцааны тоо :..... Регистр № .....

Хурлаар шийдвэрлэх асуудлууд:

1. “Номин реалтор” ХХК-тай байгуулсан Барилгын ажлын захиалагчийн эрх шилжүүлэх гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй бөгөөд их хэмжээний хэлцлийг батлах。  

а. Зөвшөөрсөн	б. Татгалзсан	в. Түдгэлзсэн
---------------	---------------	---------------
2. “Номин реалтор” ХХК-тай байгуулсан Түрээсийн гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй бөгөөд их хэмжээний хэлцлийг батлах。  

а. Зөвшөөрсөн	б. Татгалзсан	в. Түдгэлзсэн
---------------	---------------	---------------
3. “Улсын их дэлгүүр” ХК нь Хaan банкнаас бага хүйтэй зээл авахтай холбоотойгоор “Номин холдинг” ХХК батлан даалт гаргах тул Улсын их дэлгүүрийн барилгыг гуравдагч этгээдэд барьцаалуулах эрхийг “Номин холдинг” ХХК-д олгохыг зөвшөөрөх.  

а. Зөвшөөрсөн	б. Татгалзсан	в. Түдгэлзсэн
---------------	---------------	---------------

Санамж:

1. Санал өгөгч нь өгөх саналынхаа өмнөх үсгийг дугуйлна.
2. Саналын хуудсыг балласан, засварласан бол хүчингүйд тооцно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_

2021/ ..... / .....

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Тооллогын комиссын дарга: \_\_\_\_\_  
Гишүүд: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_